



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН 2020





Өмнөх үг	2
М-Си-Эс Группийн тухай	4
Эрхэм зорилго, үнэт зүйлс, баримтлах зарчим	5
Тогтвортой хөгжлийн зорилтууд	7
Ковид-19 цар тахлын үед авсан арга хэмжээ	8
Нийгмийн төслүүд	13
Нийгэм, эдийн засагт оруулж буй хувь нэмэр	19
Байгаль орчин	20
М-Си-Эс Группийн ажилтнууд	27
Хөдөлмөрийн аюулгүй байдал	28



ӨМНӨХ ҮГ

2020 он дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахлын нөлөөллийн улмаас хувийн хэвшил төдийгүй улс оронд тааварлашгүй сорилт, бэрхшээл ихтэй жил байлаа. Тайлант онд М-Си-Эс Групп нийгмийн хариуцлагын нийт 100 гаруй төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, 14 тэрбум төгрөг зарцуулжээ. Монгол Улсад ковид-19 халдвар тархсанаас хойшхи хугацаанд М-Си-Эс Группийн компаниуд нийт 600 сая орчим төгрөгийн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, бэлэн мөнгө, хандив, тусламжийг цар тахалтай тэмцэх үйл ажиллагаа, арга хэмжээнд зориулж албан байгууллага, албан хаагчид, хувь хүмүүст хүргэсэн байна. Түүнчлэн бид өөрийн болон бусад эх үүсвэрээр хөрөнгө оруулалтууд хийн тогтвортой ажлын байр шинээр бий болгож, түүнийгээ хадгалах бодлогыг тууштай баримтлан ажиллаж байна.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, тэр дундаа уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр нөлөөг багасгах зорилтыг бид бизнесийн үйл ажиллагаа, нийгмийн хариуцлагын үйлсдээ мөрдлөг болгон ажиллахыг зорьдог. Энэхүү зорилтоо бид агаарын бохирдлыг бууруулах бодлоготой уялдуулан, энэ талаарх төсөл хөтөлбөрүүдийг дэмжин ажилладаг билээ. Тухайлбал, Энержи Ресурс компани нь Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр”-ийг дэмжих зорилгоор 2018 оноос эхлэн сайжруулсан түлшний түүхий эд буюу Ухаа худагийн угааж баяжуулсан эрчим хүчний нүүрсээр үнэ төлбөргүй хангаж байна. Тайлант онд уг хөтөлбөрт долоо тэрбум орчим төгрөгийн үнэ бүхий 313 мянган тонн нүүрсийг үнэ төлбөргүй нийлүүлжээ.

М-Си-Эс Кока-Кола нэгж бүтээгдэхүүнд зарцуулагдах усны хэмжээг тогтмол бууруулах зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд 2001 оноос хойш өдийг хүртэл нэгж бүтээгдэхүүнд зарцуулах усны хэмжээг гурав дахин бууруулан ажиллаж, 2020 онд 1л бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд 1,86л ус зарцуулдаг болоод байна. Түүнчлэн тус компани үйлдвэрээс гарах хог хаягдалдаа ангилан ялгалт хийн дахин боловсруулах үйлдвэрүүдэд түүхий эд болгон хүлээлгэн өгдөг ба 2020 онд нийт хог хаягдлын 50 хувийг дахин боловсруулалтад нийлүүлэв. Мөн Энержи Ресурс компанийн Ухаа Худаг уурхайн цогцолбор нь үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний ус хангамжийн ухаалаг, дэвшилтэт системийг нэвтрүүлэн ажилласнаар уурхайн нийт төслийн усны хэрэгцээг хангадаг. 2020 онд усны менежмент, технологийн горимд сайжруулалт хийснээр үйлдвэрлэлд дахин ашиглах усны хэмжээг 11 орчим хувиар нэмэгдүүлсэн.

Үндэсний өв соёл, үнэт зүйлсийн бэлгэ тэмдэг болсон түүх соёлын дурсгалыг хадгалж хамгаалах зорилготой “Өв Эрдэнэ” хөтөлбөр 2019 оноос хэрэгжиж эхэлснээс хойш Чойжин ламын сүм болон Богд хааны ордон музей, Занабазарын музей, Амарбаясгалант хийд тэргүүтэй долоон төсөлд нийт 1.7 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгоод байна. “Өв Эрдэнэ” тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд соёлын дурсгалт газрууд болон дурсгалт уран барилгын нөхцөл байдал эрсдэлийн судалгаа шинжилгээ, барилгын сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалтын төлөвлөлтийн чиглэлээр төслүүд хэрэгжүүлж байна.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН 2020

Бид Монгол Улсад багийн спортыг хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжин ажилласаар ирсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд нийт 120 мянга орчим сагсан бөмбөг сонирхогч хүүхэд залуусыг хамруулсан тэмцээнийг зохион байгуулж, тэдний дундаас шигшигдэж гарч ирсэн залуус маань өнөөдөр дэлхийн тавцанд Монгол Улсынхаа нэрийг дуурсгаж эхлээд байна. Өдгөө Монгол Улс анх удаа 2020 оны Токиогийн Олимпод багийн спортоор оролцох эрх аваад байгаа бөгөөд Энержи Ресурс компани 3х3 сагсан бөмбөгийн үндэсний шигшээ багуудын албан ёсны түншээр ажиллаж байгаа бөгөөд 2020 онд “Энержи 3х3” мэргэжлийн клубыг байгуулан, шигшээ багуудын байнгын бэлтгэл сургуулилтыг ханган, бүс нутаг, тив дэлхийн тэмцээнүүдэд оролцох бүх боломжийг бүрдүүлэн, баг тамирчдаа зөвхөн тэмцээний бэлтгэлдээ анхаарлаа хандуулж, хүчин чармайлтаа гаргахад дэмжлэг болон ажиллаж байна.

М-Си-Эс Групп нь олон улсад тэргүүлэгч хөрөнгө оруулалтын сан болох Cerberus Capital Management /Серберус/ компанитай хэлэлцээр хийж, олон улсын хөрөнгө оруулалтын сантай түншилснээр нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн зорилтуудыг үйл ажиллагаандаа нийцүүлэн ажиллахад нэгэн чухал алхам боллоо. Уг түншлэлийн хүрээнд эхний шатанд М-Си-Эс Группийн харилцаа холбоо болон өргөн хэрэглээний барааны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг долоон компанид байгаль орчин, нийгэм, засаглалын нийцлийн системийг бий болгож байгаа бөгөөд цаашлаад Монгол Улс болон олон улсын түвшинд тайлагнах эхлэл болж байгаа юм.

Бид аливаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтдаа үндэсний компаниудаа бүхий л талаар дэмжин оролцуулж, дотоодын аж ахуйн нэгжүүд тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэхийг эрмэлздэг бөгөөд мөн онд нийт 1.4 их наяд төгрөгийн худалдан авалт хийснээс дотоодын 3000 орчим аж ахуйн нэгж, 527 хувь хүнээс 1.1 их наяд төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авсан байна.

Ийнхүү бид 2020 онд дунджаар өдөр бүр 1.2 тэрбум, сард 37 орчим тэрбум төгрөгийн татвар, шимтгэлийг төвлөрүүлж, өөрийн 10 мянган ажилтандаа сард 20 орчим тэрбум төгрөгийн цалин, урамшуулал олгохоос гадна дотоодын 3000 орчим бизнес эрхлэгчээс сард 100 орчим тэрбум төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авч, шууд бусаар 20 мянган хүнийг тогтмол ажлын байртай болгож, сард доод тал нь 20 орчим тэрбум төгрөгийн цалин тавих боломжийг олгон улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмрийг оруулж, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа хэрэгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.



Хүндэтгэсэн,

М-Си-Эс Группийн Дэд Ерөнхийлөгч

Д.Энхтүвшин



М-СИ-ЭС ГРУППИЙН ТУХАЙ

Эрчим хүчний зөвлөгөө өгөх чиглэлээр 1993 онд үүсгэн байгуулагдсан М-Си-Эс компани шилжилтийн он жилүүдэд олон салбарт бизнесийн үйл ажиллагаа эрхлэн, улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулсаар ирсэн бөгөөд өдгөө татвар шимтгэл, хөрөнгө оруулалт, ажлын байр зэрэг үзүүлэлтээр тэргүүлэгч үндэсний томоохон Групп болоод байна.

Аливаа улс орны хөгжлийг шинэ шатанд хүргэдэг дэд бүтэц, эрчим хүч, инженеринг, мэдээлэл, харилцаа холбоо, барилга, үл хөдлөх хөрөнгийн салбар, эдийн засгийг үлэмж тэтгэдэг уул уурхай, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний салбар, нийгмийн сайн сайхан, хүний хөгжлийг дэмждэг эрүүл мэнд, боловсрол зэрэг чухал салбарт ажилласан он жилүүддээ бид тогтсон байгууллагын соёлтой, төлөвшсөн боловсон хүчинтэй, түүчээлэх өрсөлдөх чадвартай Групп болон тэлжээ.

Бизнесийн цар хүрээ тэлж, компаниуд маань өсч томрохын хэрээр нийгэм, улс орныхоо өмнө хүлээх бидний үүрэг, хариуцлага улам бүр өндөрсөж, дэлхийн стандарт, дэвшилтэт техник, технологийг эх орондоо нэвтрүүлж, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.

М-Си-Эс Групп нь олон улсад тэргүүлэгч хөрөнгө оруулалтын сан болох Cerberus Capital Management /Серберус/ компанитай хэлэлцээр хийж, М-Си-Эс Холдинг Нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн албыг байгуулж байгаль орчин, нийгэм, засаглалын нийцлийн системийг нэвтрүүлж, урт хугацаандаа тогтвортой хөгжлийн зорилтуудад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллахаар зорьж байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО: “ДЭЛХИЙН ХӨГЖЛИЙГ МОНГОЛД” ҮНЭТ ЗҮЙЛС, БАРИМТЛАХ ЗАРЧИМ



МЭРГЭШСЭН ӨНДӨР ЧАДАВХ

Мэргэжлийн өндөр ур чадвартай, өөрийгөө болон бусдыг байнга хөгжүүлдэг



БАГИЙН СЭТГЭЛГЭЭ

Харилцан итгэлцэл, хүндлэл, зэрэг дулаан харьцааг буй болгон хамт олонтойгоо үр дүнтэй хамтран ажилладаг



МАНЛАЙЛАЛ

Цаашдын ахиц, хөгжлийн боломжийг олж тодорхойлж, бусдадаа ойлгуулан дэмжлэгийг нь авч, тэднийг урам зоригжуулан, хамтдаа бодит үйл хэрэг болгодог



ӨӨРИЙМСӨГ ҮЗЭЛ

Ажилдаа болон компанидаа өөриймсөг хандаж, сэтгэл гарган ажилладаг



САНАЛ САНААЧИЛГА

Хөгжүүлэх, сайжруулах, асуудлыг шийдвэрлэх бүтээлч шийдэл, санал санаачилгыг байнга гаргадаг



ҮНЭНЧ ШУДАРГА ЗАРЧИМ

Монгол Улсын хууль журмыг алхам тутамдаа дээдэлдэг, аливаад үнэнч шударга ханддаг



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАРЧИМ

Нийгэмдээ болон байгаль орчиндоо ээлтэй байхыг эрхэмлэдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлыг эн тэргүүнд хангаж ажилладаг

БАРИМТЛАХ ЗАРЧМУУД

- Өөрийгөө болон бусдыг хөгжүүлэх нь ажилтан бүрийн эрхэм үүрэг байна.
- Бид ажилтан бүрт хөгжиж, ахиж дэвших орчныг бүрдүүлж, ижил тэгш бололцоо олгоно. Ажилтны өсөж хөгжих, дэвжиж дээшлэх нь тухайн хүний ур чадвар, гүйцэтгэл, оруулж буй хувь нэмэртэй шууд холбоотой байна.
- Бид сайн ажилчин, ажилтан, менежер төдийгүй сайн манлайлагч байхыг эрмэлзэж, бусдадаа үлгэр дууриал үзүүлнэ.
- Бид шинийг сэдэж, аливааг сайжруулах боломжийг цаг ямагт эрэлхийлнэ. Бид шинэ санаа, бүтээлч хандлагыг хөхиүлэн дэмжинэ.
- Бид хамгийн шилдэг шийдэл бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэнэ.
- Өндөр чадавх, олон ургальч санаа бодол бүхий гишүүдээс бүрдсэн, харилцан итгэлцэл, хүндлэлд суурилсан хамтын зүтгэл нь бидний тогтвортой амжилтын үндэс юм.
- Бид зах зээлийн шударга зарчимд тулгуурлан харилцан биенээ дэмжиж, нөхөж ажилласнаар улам их үр дүн гаргах боломж бололцоогоо нэмэгдүүлнэ.
- Бид ажилдаа эзний сэтгэлээр хандаж, компанийн нэр хүнд, өмч хөрөнгийг хайрлан хамгаална.
- Бид зөв зүйлийг зөв арга замаар хийж, Монгол Улсын хууль тогтоомж, М-Си-Эс Группийн Ёс зүйн дүрмийг өдөр тутам мөрдөж ажиллана.
- Бид ажилтан, түнш, хэрэглэгчтэйгээ харилцахдаа үнэнч шударга зарчмыг баримтална.
- Бид нийгэмдээ болон байгаль орчиндоо ээлтэй байхыг эрхэмлэнэ.
- Бид хөдөлмөрийн аюулгүй байдлыг эн тэргүүнд хангаж ажиллана.

Бид алхам тутамдаа М-Си-Эс-ийн үнэт зүйлс, баримтлах зарчмуудыг дээдэлнэ.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД

М-Си-Эс Группийн үнэт зүйлсийн нэг болох тогтвортой хөгжлийн зарчмыг бид бизнес болон өдөр тутмын үйл ажиллагаа, нийгмийн хариуцлагын үйлсдээ мөрдлөг болгон ажиллахын зэрэгцээ сайн засаглал бүхий төрийн бус байгууллагуудтай түншлэн нийгмийн төлөөх төсөл хөтөлбөрүүдийг илүү үр өгөөжтэй, өргөн цар хүрээтэй хэрэгжүүлэхийг зорьдог. М-Си-Эс Групп нь тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцсэн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангахад түлхүү анхааран ажиллаж, цаашлаад байгаль орчин, нийгэм, засаглалын нийцлийн тайлагналтын хүрээнд жил бүр тогтвортой хөгжлийн тайлан гаргахаар ажиллаж байна.

SUSTAINABLE DEVELOPMENT GOALS



КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

BE STRONG АЯН

Цар тахлын халдвар тархсанаас хойш хугацаанд М-Си-Эс Группийн компаниуд нийт 600 орчим сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, бэлэн мөнгө, хандив, тусламжийг цар тахалтай тэмцэх үйл ажиллагаа, арга хэмжээнд зориулж албан байгууллага, албан хаагчид, хувь хүмүүст хүргэсэн.

Ковид-19 цар тахлын халдвар улсын хэмжээнд тархаж, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн онцгой цаг үед М-Си-Эс Групп сайн дурын санал, санаачилгад идэвхтэй дэмжин оролцож байна. Нэн тэргүүнд иргэдийнхээ аюулгүй байдлын төлөө цаг сунган эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгаа салбарынхан, ажилтан, албан хаагчдад шаардлагатай тусламж, дэмжлэгийг хүргэхийг зорьж, "Be Strong" уриан дор хандив тусламжийн аян өрнүүлсэн.



ЦАГ ҮЕИЙН ХАНДИВ, ТУСЛАМЖ

Юнител Групп дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахлын үеэр Улсын онцгой комисст тэргүүн шугамд ажиллаж буй төрийн албан хаагч нарт дэмжлэг үзүүлэх зорилгоор мөнгөн тусламж, орон даяарх онцгой комиссын байнгын хуралд зориулж онлайн хурлын систем, дагалдах бүтээгдэхүүн үйлчилгээг тус тус хандивлав

Юнител Групп цар тахлын үед УОК, ЭМЯ, НОК, ОБЕГ-ын үйл ажиллагааг дэмжихэд чиглэн нийт хэрэглэгчдэд ковид-19 зөвлөмж, цаг үеийн мэдээллийг тогтмол хүргэж байна. 2021 оны нэгдүгээр сарын байдлаар нийт 150 сая мессеж илгээсэн байна.



КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

ЦАГ ҮЕИЙН ДЭМЖЛЭГ

М-Си-Эс Кока-Кола компанийн зүгээс цар тахлын үед ЭМЯ, ХӨСҮТ болон орон нутгийн ОБГ-ын нэн тэргүүнд, өндөр ачаалалтай ажиллаж буй ажилтан, албан хаагчдад зориулан үнэ бүхий бүтээгдэхүүнийг. Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн төвд 10 сая төгрөгийн үнэ бүхий нэн шаардлагатай амьсгалын тоног төхөөрөмжийг тус тус хандивлав.

М-Си-Эс Кока-Кола компани албан бичгээр ирсэн сайн дурын үйл ажиллагаа, хандив тусламжаар нийт 87 сая гаруй төгрөгийг нийгмийн хариуцлагын хүрээнд холбогдох аж ахуй нэгжүүдэд хандивлав.

Юнител Групп цар тахлын үед ЭМЯ, Зооноз өвчин судлал, ХӨСҮТ, ОБЕГ, ЦЕГ-ын Улаанбаатар болон орон нутгийн салбаруудад шилэн кабелийн интернэт, технологийн бүтээгдэхүүн үйлчилгээг үнэгүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр үзүүлж дэмжин ажилласан.



Тотал Дистрибьюшин компани 21 аймгийн Онцгой байдлын газарт үнэ бүхий шатахуун болон бараа бүтээгдэхүүний тусламж үзүүлсэн.



КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ БҮТЭЭГДЭХҮҮН

ВэллБий компани эрүүл мэндийн салбарын эмнэлгүүд, дүүргийн эмнэлгүүд, халдварт өвчин судлалын төвүүд, хүрээлэнгүүд болон амаржих газруудын ажилтан, эмч нарын дархлаа, эрүүл мэндийг дэмжих зорилгоор амин дэм, бэлдмэл, антибиотик, элэг хамгаалах зэрэг 225 сая төгрөг орчмын бүтээгдэхүүнийг хандивлан эмчилгээнд хэрэглүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

DRIVE-THROUGH ШИНЖИЛГЭЭ

Интермед эмнэлэг нийгмийн хариуцлагын хүрээнд ковид-19 цар тахлын үед эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд өөрсдийн хувь нэмрийг бодитоор оруулан нийслэлийн хэмжээнд коронавирусийн халдвар илрүүлэх түргэвчилсэн оношилгооны 20 орчим цэг дээр ажиллаж байна. Түүнчлэн Интермед эмнэлэг иргэдэд Коронавирусийн шинжилгээг Drive-through урсгал буюу автомашин дотроосоо гаралгүйгээр өгөх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.



И-КЛИНИК ПЛАТФОРМ

Интермед эмнэлэг нь И-Клиник эрүүл мэндийн платформын багтай хамтран нийгмийн хариуцлагын хүрээнд ковид-19 халдвар дамжуулах эрсдэлийг бууруулах зорилгоор ковид-19 халдварын эрсдэлийг үнэлэх онлайн интерактив асуумжийг танилцууллаа. Энэ нь халдвараар

өвчилсөн эсвэл ковид-19 өвчтэй хүнтэй хавьталд орсон гэж үзэж байгаа бол эрсдэлийг зайнаас үнэлэн ковид-19 шинжилгээ өгөх эсвэл эрүүл мэндийн зохих тусламж үйлчилгээг авах эсэх шийдвэр гаргахад туслах эрсдэлийн үнэлгээний асуумж юм.



КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

ОРОН НУТАГ ДАХЬ ДЭМЖЛЭГ, ТУСЛАЛЦАА

Энержи Ресурс компани ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллах, дэмжих чиглэлээр Цогтцэций Сумын Онцгой комисс, сум дундын эмнэлэгт мөнгөн тусламж болон постны байр, гэрэлтүүлэг, хөдөлгөөнт эргүүлийн машин, хоол хүнс, халдвар хамгааллын эд материалын тусалцаа үзүүлсэн.

Мөн Өмнөговь аймгийн Онцгой комисст “Ковид-19”-ын 1,500 ширхэг, Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо, Цогт-Овоо, Ханхонгор сумдад 1,800 ширхэг, нийт 3,300 ширхэг түргэвчилсэн оношлуурын тестийг тус тус хандивласан байна.

ЯВУУЛЫН ЭМНЭЛЭГ ТӨСӨЛ

“Явуулын эмнэлэг” төслийн хүрээнд Интермед эмнэлэг нь жил бүр алслагдсан сум, багт очин нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээг газар дээр нь үнэ төлбөргүй хийж байна. 2020 онд Өмнөговь аймгийн Даланзадгад, Цогтцэций сумдад үзлэг оношилгоо хийж, олон улсын жишигт нийцсэн нарийн мэргэжлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэсэн байна.

Мөн эрүүл мэндийн ажилтнуудыг чадваржуулах хөтөлбөрийг тогтмол зохион байгуулдаг бөгөөд энэ хүрээнд Интермед эмнэлгийн Сувилахуйн баг “Үйлчлүүлэгчийн Аюулгүй байдал” сэдэвт сургалтыг Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газарт зохион байгууллаа. Сургалтад Дорноговь аймгийн сумын эмнэлгүүдийн төлөөлөл төр ба хувийн хэвшлийн 23 эрүүл мэндийн байгууллагын 46 эмч мэргэжилтэн хамрагдан мэдээлэл солилцсон байна.



КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

ЗҮРХНИЙ ЭМГЭГТЭЙ ХҮҮХДҮҮДЭД “АМЬДРАЛ ХАЙРЛАХ” ТӨСӨЛ

Энержи Ресурс компани Монголын Улаан Загалмай Нийгэмлэгтэй хамтарсан “Бяцхан зүрх” төслийг 2018 оноос хэрэгжүүлж, төрөлхийн зүрхний гажигтай, дотооддоо эмчлүүлэх боломжгүй, амьдралын боломж муутай хүүхдүүдийг хилийн чанадад хагалгаанд оруулж, эмчилгээний бүх зардлыг бүрэн дааж ирсэн. Одоогийн байдлаар нийт 40 гаруй хүүхэд уг төсөлд хамрагдан, БНХАУ-ын улсын эмнэлгүүдэд эмчлэгдэн, эдгэрээд байна. 2020 онд “ковид 19” цар тахлын улмаас хил хаагдсантай холбогдуулан бид төрөлхийн зүрхний гажигтай хүүхдүүдэд туслах сайн үйлсийн аянаа үргэлжлүүлж, “Сонгдо” эмнэлэгтэй хамтран ажилласан. Тус эмнэлгээс санаачлан хэрэгжүүлж буй “Зүрх мартахгүй” төслийг дэмжин зүрхний гажигтай таван хүүхдийн мэс заслын эмчилгээний зардлыг бүрэн санхүүжүүлж, амьдрал бэлэглэсэн.



ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ИРГЭДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Интермед эмнэлэг үйл ажиллагаа явуулж эхэлсэн цагаасаа тусгай хэрэгцээт иргэдийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд Хан-Уул дүүргийн болон Түгээмэл хөгжил ТББ-ын тусгай хэрэгцээт иргэдийг үзлэг оношилгоонд тогтмол хамруулах, шинээр ажлын байр бий болгох, ээлтэй орчин бүрдүүлэн ажиллаж байна. Түүнчлэн эмнэлгийн гадна болон дотор хэсэгт тусгай хэрэгцээт иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэхээр брайл үсгэн мэдээлэл, цахилгаан шатны зарлан мэдээлэх системийг шинэчлэв. Интермед эмнэлэг нь тусгай хэрэгцээт иргэдэд зориулж ажлын байрыг шинээр бий болгон, ажлын байраар тогтмол ханган ажилладаг.

БОЛОВСРОЛ

ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ

Цар тахлын үед ЕБС-ийн сурагчдын онлайн хичээлд оролцох боломжийг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх зорилгоор Юнивишний боловсролын контент “Гэрийн багш” цэсийг гурван сар, онлайн хичээлүүдийг агуулсан econtent.edu.mn болон help.eec.mn вебхуудаст хандах датаг үнэгүй болгосон.

М-Си-Эс Эстэйтс компанийн ажилтнуудын зүгээс "Ид шидийн орон - 2" ХХХТ-ийн (Лантуун Дохио ТББ) өсвөр насны хүүхдүүдэд хүсэл мөрөөдөл, тэгш боломж, хандлага, тэтгэлэг, боловсролын талаар дөрвөн удаагийн цуврал лекцийг зохион байгууллаа.



ОРОН НУТГИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР


Энержи Ресурс компани орон нутгийн боловсролыг дэмжих хөтөлбөрийг 2013 оноос хойш үе шаттай хэрэгжүүлж, 2019 оноос шинэчилсэн байдлаар үргэлжлүүлж байна. Цогтцэций сумын хоёр дунд сургуулийн нийт 2,000 гаруй сурагч хамрагддаг уг хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатараас чадварлаг багш, зөвлөхүүдийг Цогтцэцийд гэрээгээр ажиллуулах, хүүхэд бүрт хүртээмжтэй математикийн онлайн хөтөлбөр нэвтрүүлэх, багш нарт гүйцэтгэл, үр дүнгийн урамшуулал олгох зэрэг ажил хийгдэж ирсэн.



СОЁЛ УРЛАГ

“ӨВ ЭРДЭНЭ” СОЁЛЫН ӨВИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Үндэсний өв соёл, үнэт зүйлсийн бэлгэ тэмдэг болсон түүх соёлын дурсгалыг хадгалж хамгаалах зорилготой “Өв Эрдэнэ” хөтөлбөр 2019 оноос хэрэгжиж эхэлснээс хойш Чойжин ламын сүм болон Богд хааны ордон музей, Занабазарын музей, Амарбаясгалант хийд тэргүүтэй долоон төсөлд нийт 1.7 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгоод байна. “Өв Эрдэнэ” тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд соёлын дурсгалт газрууд болон дурсгалт уран барилгын нөхцөл байдал эрсдэлийн судалгаа шинжилгээ, барилгын сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалтын төлөвлөлтийн чиглэлээр төслүүд хэрэгжүүлж байна.



ОЛИМП ХҮРЭХ ЗАМ

БАГИЙН СПОРТ

Монгол Улсад багийн спортыг хөгжүүлэх зорилтын хүрээнд Энержи Ресурс компани 3х3 сагсны үндэсний шигшээ багуудын албан ёсны түншээр ажиллаж байна. Энэ хүрээнд Монголдоо анх удаа "Энержи 3х3" мэргэжлийн клубийг байгуулан, шигшээ багуудын байнгын бэлтгэл сургуулалт, бүс нутаг, тив дэлхийн тэмцээнүүдэд оролцох бүх боломжийг бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд одоогоор тус клубд мэргэжлийн зургаан баг харьяалагдаж байна. Үр дүнд нь Монгол Улс анх удаа 2020 оны Токиогийн Олимпд багийн спортоор оролцох эрх аваад байна. Мөн "UB Challenger", Азийн аварга, Дэлхийн аварга зэрэг олон улсын тэмцээнийг эх орондоо зохион байгуулж дэлхий нийтэд өөрсдийн нөөц бололцоогоо бататган харуулсан.



БАЙТ ХАРВАА

Интермед эмнэлэг Монголын байт харвааны холбоотой хамтран ажиллах "Хамтын ажиллагааны санамж бичиг"-ийг байгуулж, Японы нийслэл Токио хотод болох 2020 оны Олимпийн наадамд Монгол Улсаа төлөөлөн оролцох эрхээ авсан Монголын байт харвааны шигшээ багийн 15 тамирчин, дасгалжуулагч нарыг урьдчилан сэргийлэх үзлэгийн төвөөрөө дамжуулан эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулан дэмжлэг үзүүлээ.



СОЁЛ УРЛАГ, СПОРТ

ХҮҮХДИЙН ТӨЛӨӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Түүнчлэн Скай Ресорт цанын бааз жил бүр амьжиргааны түвшин доогуур айл өрхийн хүүхдүүдэд, бүтэн өдрийн арга хэмжээ зохион байгуулдаг бөгөөд 2020 онд цар тахлын халдварын үед буюу хоёрдугаар сарын эхээр Олон улсын улаан загалмайн байгууллагатай хамтран 1000 хүүхдийг, олон улсын FNI хүүхдийн байгууллагатай хамтран 300 – 400 хүүхдийг үнэ төлбөргүй гулгуулах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан.



Анунгоо компани нийгмийн хариуцлагын хүрээнд бүтэмжийн

зөвлөлийн урамшууллын олговроор Худалдан авалт, ложистик алба (агуулах, түгээлт)-ны ажилчдын хүүхдүүдийн ирээдүйд хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн зөв зохион байгуулалтыг бий болгох зорилгоор нийт 144 хүүхдэд 30 мянган төгрөгийн хадгаламж нээжээ.

“БЭЛГЭЭ БЭЛЭГЛЭЭ” КАМПАНИТ АЖИЛ

Юнител Групп шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх хэв маягаа өөрчилж харилцагчдадаа биет бэлэг өгөлгүй дижитал бэлэг илгээх "Бэлгээ бэлэглээ" кампанит ажлыг хэрэгжүүллээ. Дижитал бэлгээр дамжуулан хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулдаг гурван байгууллагад бэлгээ бэлэглэх сонголтыг санал болгож бусдад хайр халамж, аз жаргал түгээх үйлсэд уриалан дуудсан юм. Тодруулбал Хүүхдийн Төв Сувилал, Монголын Гимнастикийн Холбоо, "Гэгээн Ирээдүй" хүүхэд хөгжлийн төв гэсэн газруудад дэмжлэг үзүүлсэн юм.

ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

ОРОН НУТГИЙН ЖДҮ, БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Энержи Ресурс компани орон нутгийн ЖДҮ, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн зээлийн санд 50 сая төгрөгийн санхүүжилт нэмэлтээр байршуулж, Цогтцэций сумын есөн иргэнд нийт 70.7 сая төгрөгийн хүүгүй зээл олгон бизнесээ эхлүүлэх, өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлжээ. Уг хөтөлбөрийг өргөжүүлэх зорилгоор Цогт-Овоо, Ханхонгор сумдад судалгаа хийж, хамрагдах хүсэлтэй иргэдтэй уулзан, мэдээлэл өгөх, бизнес төсөл боловсруулах сургалтыг орон нутгийн “Амжилтын томъёо” ТББ-тай хамтран зохион байгуулсан.



ХЭРЭГЛЭГЧДЭД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

HAPPINESS CENTER

М-Си-Эс Кока-Кола Монгол Улсын ирээдүй болсон хүүхэд залуусын оюуны боловсролыг дэмжих зорилгоор HAPPINESS CENTER-ийг 2012 оноос эхлэн есөн жилийн хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Хүүхэд залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулан сурган хүмүүжүүлэх, хувь хүний хөгжилд чиглэсэн сургалт, лекц, арга хэмжээг үнэ төлбөргүйгээр зохион байгуулдаг билээ. Тус төв нь жилд дунджаар 1000 орчим удаагийн арга хэмжээ, сургалт, лекц, арга хэмжээг зохион байгуулж 95 мянга гаруй зочинд хүрч үйлчлээд байна.



ЭМЗЭГ БҮЛГИЙН ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Анунгоо компани эмзэг бүлгийн өрх толгойлсон эмэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор нийт 12,7 сая төгрөгийн үнэ бүхий Pampers живхийг хандивласан байна.



НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

ТАТВАР ТӨЛӨЛТ

Бизнесийн цар хүрээ тэлж, компаниуд өсч томрохын хэрээр нийгэм, улс орныхоо өмнө хүлээх бидний үүрэг, хариуцлага улам бүр өндөрсөж, дэлхийн стандарт, дэвшилтэт техник, технологийг эх орондоо нэвтрүүлж, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.

Өдөрт нэг тэрбум, сард 30 тэрбум орчим төгрөгийн татвар, шимтгэлийг улсын төсөвт төвлөрүүлж, өөрийн 10 мянган ажилтандаа сард 16 тэрбум төгрөгийн цалин олгохоос гадна дотоодын 3000 орчим бизнес эрхлэгчээс сард 100 гаруй тэрбум төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авч, шууд бусаар мөн 20 мянган хүнийг тогтмол ажлын байртай болгож, сард доод тал нь 20 тэрбум орчим төгрөгийн цалин тавих боломжийг олгон улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой, том хувь нэмрийг оруулж байна.

М-Си-Эс Группийн охин болон хөрөнгө оруулалттай компаниуд сүүлийн арван жилд нийт гурван их наяд төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээд байна. 2020 онд М-Си-Эс Группийн охин компаниуд нийт 444 сая төгрөгийн татвар, шимтгэлийг төлөөд байна.



НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

MCS

*(М-Си-Эс Группийн охин болон хөрөнгө оруулалттай компаниудын 2020 оны гүйцэтгэл)

ТАТВАР ШИМТГЭЛ

**444**

тэрбум төгрөг

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

**343**

тэрбум төгрөг

ХУДАЛДАН АВАЛТ

**1.4**

их наяд төгрөг

(Дотоодын 3000
ААН, 527 хувь хүн)

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

**14**

тэрбум төгрөг

(100 гаруй
төсөл хөтөлбөр)

БАЙГАЛЬ ОРЧИН

АГААР ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ

Энержи Ресурс компани нь Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр”-ийг дэмжих зорилгоор 2018 оноос сайжруулсан түлшний түүхий эд буюу Ухаа худагийн угааж баяжуулсан эрчим хүчний нүүрсээр үнэ төлбөргүй хангаж байна. Уг хөтөлбөрт 2018-2020 оны хугацаанд 18,8 тэрбум төгрөгийн өртөг бүхий 1 сая тонн нүүрсийг үнэ төлбөргүй нийлүүлжээ. Үүнээс 2020 онд 7 орчим тэрбум төгрөгийн үнэ бүхий 313 мянган тонн нүүрсийг үнэ төлбөргүй нийлүүлжээ.



БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ХИЙН ЗУУХ

М-Си-Эс Кока-Кола компани 2020 онд Монгол Улсдаа хүнсний үйлдвэрлэлийн салбар дундаас анх удаа байгаль орчинд ээлтэй хийн зуухыг ашиглалтад оруулсан компани боллоо. Энэ нь холбогдох тогтоол, заалтуудыг хангасан, Япон улсын NTEC компанийн 0.6 Гкал/цаг хүчин чадалтай найман ширхэг ус халаалтын зуух, БНСУ-ын DAEEYOL компанийн 4 тонн/цаг хүчин чадалтай дөрвөн ширхэг уурын зуух болон холбогдох дэд бүтэцтэй бүтээн байгуулалт болсон юм. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр жилд 7000 тонн түүхий нүүрсний хэрэглээг багасгаж, агаар орчны бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулах давуу талтай.



БАЙГАЛЬ ОРЧИН

АГААР БОХИРДУУЛАГЧ ХИЙН ЯЛГАРАЛ БАГАТАЙ ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН ШИНЭЧЛЭЛ

Тотал Дистрибьюшин компани тээвэр, түгээлтийн үйл ажиллагаанд нэн тэргүүнд хөдөлмөрийн аюулгүй байдал, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, хадгалах, тээвэрлэх горимыг хангасан автомашины парк шинэчлэлийн ажлыг хийлээ. Уг ажлын хүрээнд түгээлтийн тээврийн хэрэгслүүд байгаль орчинд ээлтэй "ЭКО Евро-5" хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийг үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна. Энэ нь хөдөлгүүрээс ялгарах агаар бохирдуулагч хий багасгах, ялангуяа азотын хүчлийн (NOx) хэмжээг 90 хувь хүртэл бууруулдаг ач холбогдолтой.



УСНЫ ХЭРЭГЛЭЭГ БУУРУУЛАХ ХӨТӨЛБӨР

М-Си-Эс Кока-Кола компани нэгж бүтээгдэхүүнд зарцуулагдах усны хэмжээг тогтмол бууруулах зорилт тавин ажилладаг бөгөөд 2001 оноос хойш өдийг хүртэл нэгж бүтээгдэхүүнд зарцуулах усны хэмжээг гурав дахин бууруулан ажиллаж, 2020 онд 1л бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд 1,86л ус зарцуулдаг болов.



БАЙГАЛЬ ОРЧИН


ХОГ ХАЯГДАЛГҮЙ ДЭЛХИЙ – 2030 ХӨТӨЛБӨР

М-Си-Эс Кока-Кола компани 2030 он гэхэд нийт хаягдал хуванцар саваа 100 хувь дахин боловсруулах, сав баглаа боодлынхоо жинг бууруулах зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд тогтвортой хөгжлийн үзлийн хүрээнд “Хог хаягдалгүй дэлхий 2030” урт хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байгаа юм.

Тухайлбал, М-Си-Эс Кока-Кола компани 2010 онд үйлдвэрлэлээс гарсан хаягдал усыг цэвэршүүлэх байгууламжийг 2010 онд ашиглалтад оруулж, зам талбайн, цэвэрлэгээ, ногоон байгууламжийн усалгаанд ашиглаж эхэлснээр хүнсний үйлдвэрлэлүүдээс анхдагч болсон юм

2020 онд нийт 180 мянган гаруй тонн. хаягдал усыг цэвэршүүлжээ. Тус байгууламж нь хоногт 2000 тонн хаягдал усыг биологийн болон MBR технологийн дагуу шүүн цэвэршүүлдэг байна.

М-Си-Эс Кока-Кола үйлдвэрээс гарах хог хаягдалдаа ангилан ялгаж дахин боловсруулах үйлдвэрүүдэд түүхий эд болгон хүлээлгэн өгдөг бөгөөд 2020 онд нийт хог хаягдлын 50 хувийг дахин боловсруулалтад нийлүүлэв. Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулах зорилгын хүрээнд сав баглаа боодлын жин бууруулах төслийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2020 онд 147 тонн PET савны хэмнэлт хийж чадсан байна.



БАЙГАЛЬ ОРЧИН

УСНЫ ХЭРЭГЛЭЭГ БУУРУУЛАХ ХӨТӨЛБӨР

Энержи Ресурс ХХК нь Ухаа Худаг уурхайн цогцолбор нь үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний ус хангамжийн ухаалаг, дэвшилтэт системийг нэвтрүүлэн ажилласнаар уурхайн нийт төслүүдийн усны хэрэгцээг хангадаг. 2020 онд усны менежмент, технологийн горимд сайжруулалт хийснээр үйлдвэрлэлд дахин ашиглах усны хэмжээг 11 орчим хувиар нэмэгдүүлсэн. Мөн ахуйн зориулалтын усны хэрэглээг бууруулах ажлыг дотооддоо зохион байгуулсан бөгөөд уг ажлын хүрээнд ажилчдын хотхон ба ажлын байрнуудад ус хэмнэгч хошууг нийт 110 шүршүүрт, усны даралт бууруулагч төхөөрөмжийг нийт 99 цоргонд, эзлэхүүн бууруулагчийг ариун цэврийн өрөөний нийт 68 бочкинд суурилуулсан бөгөөд ахуйн хэрэгцээний усны хэрэглээг бууруулахад холбогдох мэдлэг, мэдээллийг нийт ажилтны сургалтын хөтөлбөрөөр дамжуулан олгосон.



БАЙГАЛЬ ОРЧИН

ХОГ ХАЯГДЛЫГ БУУРУУЛАХ ХӨТӨЛБӨР

Энержи Ресурс компани Уурхайн туслах үйл ажиллагаанаас үүсдэг хог хаягдлын нэлээдгүй хувийг хоол үйлдвэрлэлээс үүсдэг хүнсний ногооны хальс эзэлдэг бөгөөд органик хог хаягдал ашиглан бордоо хийх нь хог хаягдлын менежментийн хувьд оновчтой нэгэн арга замд тооцогддог. Тиймээс бид ажилчдын кэмп болон оффисын хоол үйлдвэрлэлээс гарсан ногооны хальс болон, мод үржүүлгийн талбайн хог ургамал зэргийг хольж бордоо хийх ажлыг туршилтаар эхлүүлж 236кг бордоог гаргаж аваад байна. Ухаа Худаг уурхайд хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхдээ “3R+R” системийг ашигладаг. Тухайлбал, ангилан ялгасан хог хаягдлыг дахин ашиглаж бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дахиврын цехийг дэргэдээ ажиллуулж, блок, хашаа, сандал, хогийн сав зэрэг олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Мөн төслийн нийт талбайн хэмжээнд их цэвэрлэгээг тогтмол зохион байгуулж, хоггүй цэвэр орчныг бүрдүүлэн ажилладаг бөгөөд тайлант хугацаанд зам талбайд тархсан хог хаягдлын цэвэрлэгээг нийт 17 удаа зохион байгуулж, нийт 6,83 м3 хог хаягдлыг цуглуулж төвлөрсөн цэгт хүргүүлсэн бол сум орон нутгаас зохион байгуулсан бүх нийтийн цэвэрлэгээнд үндсэн болон гэрээт компанийн 127 хүн оролцож нийт 52м3 хог хаягдлыг түүж цуглуулан цэвэрлэсэн.



БАЙГАЛЬ ОРЧИН

ЧОЙЖИН ЛАМЫН СҮМ МУЗЕЙН ТОХИЖИЛТЫН ТӨСӨЛ

Чойжин ламын сүм музейн 2 га эдэлбэр газрын тохижилтын төслийг нийт 1.1 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлж, 3000 бут сөөг бүхий 8500 м.кв ногоон байгууламж, 1500 м.кв авто зогсоол, 1600 м.кв явган хүний боржин чулуун замыг шинэчлэн байгуулж, сүмийн үзэмжийг тодруулсан барилгын фасад болон гадна орчны гэрэлтүүлэг суурилуулсан.



БАЙГАЛЬ ОРЧИН

БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Энержи Ресурс компани “Ухаа худаг” уурхайн техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсан гадаад овоолгын техникийн ба биологийн нөхөн сэргээлтийн ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, нөхөн сэргээлтийн ажлыг Монгол Улсын холбогдох стандартын



шаардлагад нийцүүлэн, зохих аргачлалын дагуу хийх ажлыг 2019 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд тайлант онд уурхайн хаягдлын овоолгыг налуулж, хэлбэршүүлсэн талбайг шимт хөрсөөр хучих биологийн нөхөн сэргээлтийн эхний үе шатны ажлыг 5 га талбайд, шимт хөрсөөр хучсан хэсэгт ургамалжуулалт хийж, биологийн нөхөн сэргээлт гүйцэтгэх ажлыг 1 га талбайд эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэв.

“ОЙН ЗУРВАС” ТӨСӨЛ

Энержи Ресурс компани цөлжилт, хөрсний доройтлын эсрэг салхины хаалт байгуулах “Ойн зурвас” төслийн хүрээнд 2020 онд 3.6 га талбайд нийт 40 өрх, 3 байгууллага 20 орчим төрлийн төмс, хүнсний ногоо тариалж 80 тонн ургац хураан авсан. Төсөлд хамрагдаж тариалалт хийсэн Цогтцэций сумын иргэд өрхийн хэрэгцээ хангаад зогсохгүй орон нутгийн зах зээлд борлуулалт хийж, өрхийн амьжиргаагаа дэмждэг.



Энержи Ресурс компани Говь нутагт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 2009 оноос хойш нийт 100 мянга гаруй мод тарьж ургуулснаас 2020 онд 9,000 орчим тарьцыг үржүүлэн бойжуулж 5,000 гаруй мод сөөгний суулгац тарьсан бөгөөд нийт модны амьдралт 85 хувиас дээш байна.

М-СИ-ЭС ГРУППИЙН АЖИЛТНУУД

АЖЛЫН БАЙР

М-Си-Эс Групп нь Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу ажилтан, албан хаагчдаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон, ажлын байрны дарамтаас ангид нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, нийгмийн даатгалд даатгуулах зэрэг үндсэн заалтуудыг мөрдөн ажилладаг. Мөн ковид-19 цар тахлын үеэр бүх ажилтныхаа ажлын байрыг хадгалж үлдэх бодлого баримтлан ажилласан.

Нийт ажилтны тоо

9770

Шууд бусаар бий болгож буй
ажлын байр

17159

Нийт эмэгтэй ажилтны тоо

3624

Нийт хөгжлийн бэрхшээлтэй
ажилтны тоо

398

Удирдах албан тушаалд буй
эмэгтэй ажилтны тоо

233

Эмэгтэй хөгжлийн
бэрхшээлтэй ажилтны тоо

70

Мэргэжилтэн түвшинд буй
эмэгтэй ажилтны тоо

1327

Ажилтан түвшинд буй
эмэгтэй ажилтны тоо

1781

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

М-Си-Эс Группийн хэмжээнд нийт 50 хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтнууд ажиллаж байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтнууд жилд хамгийн багадаа нэг удаа хурал, уулзалт зохион байгуулж өөрсдийн компанийн сайн туршлага, сургамжтай кейс болон цаашид хэрэгжүүлэх ажлын зорилго, зорилтын талаар хэлэлцэж, санал бодлоо солилцдог.

2020 онд М-Си-Эс Группийн хэмжээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад давхардсан тоогоор 13,700 ажилтан хамрагдсан байна.

LTIFR per 100 FTE буюу 200 000 хүн цаг тутамд ноогдох хугацаа алдсан гэмтлийн тоо 2019 онд 0.08 байсан бол 2020 онд 0.33 болж нэмэгдсэн байна.

Бид бүх осолд дөхсөн тохиолдол болон бодитой осол зэргийг мэдээлж, бүртгэн судалдаг. Ингэснээр осол бүрд тохирсон хариу арга хэмжээг авч дахин осол гарахаас сэргийлэх, жил бүрийн зорилтоо тодорхойлох, тасралтгүй сайжруулалтыг хийхэд дөхөм болдог.





ДЭЛХИЙН ХӨГЖЛИЙГ МОНГОЛД



2020 он